



ОАГ
ОРХОН АУДИТЫН ГАЗАР

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

**“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”
ҮАГ-НАГ/2017/04-НА**



Сонгуулийн зардлыг бодитой төлөвлөөгүйгээс үр ашиггүй, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулж, аймгийн сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

**Орхон аймаг
2017 он**



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 13

Эрдэнэт

Г Тайлан баталгаажуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Нийцлийн аудитын түр журмын 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 тоот тушаал, YAГ-ын нэгдсэн удирдамжаар хийгдсэн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, YAГ-т хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, санхүүгийн тайлангийн аудитын ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Г.Оргилмөрөн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



НАРМАНДАХ

07.002.6

Аудитын тайланг бэлтгэсэн:		АГУУЛГА	
		Товчилсон үгийн тайлбар	2
Орхон аймгийн Аудитын газар		Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:	3-4
		Бүлэг-1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг бодитой төлөвлөөгүйгээс үрэлгэн зарцуулжээ.	5-7
Дарга, тэргүүлэх аудитор :	Ц.Нармандах	Бүлэг 2. Сонгууль зохион байгуулах зардал, хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.	8-9
Аудитын менежер:	Б.Эрдэнэ	Дүгнэлт, Зөвлөмж	10
		Холбогдох байгууллагын санал Хавсралтууд Тэргүүлэх аудиторын тушаал	11
Ахлах аудитор	В.Жавзмаа		
Аудитор	Г.Оргилмөрөн		

2017 оны 7
дугаар сар

Уг тайланг
Орхон аймаг дахь
төрийн аудитын
газрын цахим
хуудаснаас
үзнэ үү.

Аудитын
тайлантай
холбоотой
асуудлаар нэмж,
тодруулах, лавлах
зүйл байвал
70357955,
70350757
дугаарын утас,
70359826
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Орхон аймаг
дахь төрийн
аудитын газар

Баян-Өндөр сум,
Хүрэнбулаг баг,
Нутгийн
удирдлагын ордон

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн Газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХХ	Сонгуулийн хэсгийн хороо
ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 02 дугаар тогтоол, Монгол улсын ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх;
2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

Аудитын хамрах хүрээ: Аудитад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн Орхон аймгийн сонгуулийн хорооны батлагдсан төсөв, төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аймгийн болон 2 сумын сонгуулийн хорооны санхүүгийн тайлан, баримт, материалыг хамруулав.

Үндсэн мэдээлэл: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийг зохион байгуулах Орхон аймгийн сонгуулийн хорооны зардалд СЕХ-ноос 159296.5 мянган төгрөг, дахин санал хураахад 56573.0 мянган төгрөгийн төсвийг тус тус баталсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр, Жаргалант сумдын 43 хэсгийн хороо байгуулагдаж, тэдгээрт 377 төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд 66947 иргэн санал өгөхөөр нэрсийн жагсаалтад бичигдсэнээс 37266 иргэн саналаа өгчээ.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;

- Сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоол;
- СЕХ-ноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудын явцыг хянан удирдах ажилтан: Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Г.Оргилмөрөн, нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын тайлан, баталгаажуулалт: Тайлангийн төслийг 2017 оны 07 дугаар сарын 24-ны өдрөөс 26-ны өдрүүдэд боловсруулж, аудитын тайланг 2017 оны 07 сарын 26-нд аудитын менежерийн, 2017 оны 07 сарын 27-нд тэргүүлэх аудиторовн хяналтад шилжүүллээ. 2017 оны 07 сарын 28-нд Тэргүүлэх аудиторроор баталгаажуулж, ҮАГ-ын НАГ-т хүргүүлэв.

Бүлэг.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн төсвийг бодитой төлөвлөөгүйгээс үр ашиггүй, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулсан байна.

1.1. СЕХ нь төсвийг бодитой төлөвлөөгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийг зохион байгуулах Орхон аймгийн сонгуулийн хорооны зардалд СЕХ-ноос 159296.5 мянган төгрөг, дахин санал хураахад 56573.0 мянган төгрөгийн төсвийг тус тус баталжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн зардалд батлагдсан 215869.5 сая төгрөгийн төсвийг СЕХ-ноос баталсан хуваарийн дагуу шилжүүлсэн, СЕХ-ноос төсөв хуваарилахдаа төсвийн хуваарь, хуваарилсан төсвийн тайлбар, аргачлал, зөвлөмжийг тус бүр хүргүүлэн ажилласан байна.

СЕХ-ноос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан тооцож, санхүүжүүлсэн хэдий ч унааны зардлыг 100 км-т 30.3 литр шатахуун зарцуулахаар тооцоолсон нь өндөр байна

1.2. Аймаг, сумын сонгуулийн хороод СЕХ-ны аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг хуваарилсан байна.

Аймгийн сонгуулийн хороо 164358.5 мянган төгрөгийн, 2 сумын сонгуулийн хороо болон 43 хэсгийн хороодод 51511.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсан байна.

Сонгуулийн зардлыг аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр, Жаргалант сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодод СЕХ-ноос ирүүлсэн төсвийн тайлбар, аргачлал, зөвлөмжийн дагуу тооцон хуваарилсан байна.

Баян-Өндөр сумын сонгуулийн хэсгийн хороодын унааны болон шатахууны зардлыг санал авах байрны газар нутгийн байршлыг харгалзахгүйгээр СЕХ-ноос баталсан аргачлал, зөвлөмжийн дагуу хуваарилжээ.

1.3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан хэдий ч анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулаагүй, төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулжээ.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос хуваарилсан 215869.5 мянган төгрөгийг зургаан удаагийн санхүүжилтээр авч, төсвийн хэтрэлт, хэмнэлт үүсгээгүй ажиллажээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн Орхон аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд аудит хийхэд батлагдсан төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулсан дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сургалтын зардал

Байнгын бус үйл ажиллагаатай сонгуулийн байгууллагын ажилтны гэрчилгээ олгох сургалтын зардалд төлөвлөгдсөн 236.0 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулан, зардал хооронд

шилжүүлэхдээ дээд шатны сонгуулийн байгууллагын шийдвэргүйгээр зарцуулсан нь СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.2-т “сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Шуудан холбооны зардал

Аймгийн сонгуулийн хорооны гишүүдэд 300.0 мянган төгрөгийн утасны нэгж тараасан хэдий ч арилжааны банк дахь харилцах дансаар гишүүд тус бүрт 65.0-118.5 мянган төгрөг буюу нийт 583.5 мянган төгрөг олгосон.

3. Унааны зардал

Дахин санал хураалтын унааны зардалд аймгийн сонгуулийн хороонд 250.0 мянган төгрөг төсөвлөгдсөнийг, аймгийн сонгуулийн хорооны 9 гишүүн, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтны харилцах дансанд шилжүүлэн олгосон.

4. Сурталчилгааны материал хүргэх зардал

Сонгогчдод сурталчилгааны нугалбар, санал авах байрны байршил, саналаа өгөхийг урьсан урилга зэргийг түгээхэд 2 суманд олгохоор төсөвлөсөн зардлыг аймгийн сонгуулийн хорооны 9 гишүүнд олгосон.

5. Саналын хуудсыг СЕХ-ноос авах, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх зардал

Саналын хуудсыг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх зардал 831.0 мянган төгрөгийг аймгийн болон Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны 16 гишүүдэд олгосон.

6. Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах холбоо болон унааны зардал

Аймгийн төв болон сумын төвөөс алслагдсан санал авах байрны даамал туршилтын болон санал авах өдөр дүн мэдээ дамжуулах үед сүлжээ ороогүй тохиолдолд сүлжээтэй газар луу хүрч мэдээ дамжуулах зорилгоор төсөвлөсөн 300.0 мянган төгрөгийг 15 хэсгийн хорооны даамлуудад шатахууны талноор олгосон байна.

7. Томилолтын зардал

- Сум, дүүргийн сонгуулийн хорооноос аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд сонгуулийн дүн, холбогдох бичиг баримтыг хүлээлгэн өгөх томилолтын зардлыг зөвхөн Жаргалант суманд олгох байтал аймгийн болон Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны гишүүдэд 208.0 мянган төгрөгийг олгож үргүй зардал гаргасан.

8. Болзошгүй зардал

- Байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдлаас гол ус үерлэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын зориулалтаар хэрэглэх зардлыг “Сонгуулийг зохион байгуулах, санал авах байруудын цахилгааны хүчдэл, эх үүсвэр нэмэгдүүлэх” ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, Роял алтай констракшн ХХК-д

3000.0 мянган төгрөг шилжүүлжээ. 4256.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 3000.0 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажил хийснээр гүйцэтгэл гаргаж, хүлээн авсан акт үйлдээгүй байна.

Харин гүйцэтгэгч компани цахилгаан үүсгэвэр сонгуулийн хороодод ашиглуулсан гэсэн тайлбар өгч байлаа.

- Дээрх зардлыг зарим зардлуудтай давхардуулан олгосон байхаар байна.

Баян-Өндөр сумын хэсгийн хороод санал авах байр тохижуулах 200.0 мянган төгрөгийн зардлаас ихэвчлэн гэрэлтүүлгийн ажлууд хийсэн тайлан мэдээ гаргажээ.

Мөн 24 хэсгийн хороонд 1666.0 мянган төгрөгийн эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардлыг шийдвэрлэсэн байна.

9. Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал

Мэдээлэл технологийн баг ICP машиныг Улаанбаатар хотод аваачих, буцаан авч ирэхэд 2 хүртэл автомашинаар тооцож, 3589.5 мянган төгрөгөөр төсөвлөн, 43 санал авах байранд 66 ICP машиныг сонгуульд ашигласан бөгөөд уг зардалд 3589.5 мянган төгрөг зарцуулжээ.

Дахин санал хураалт болохтой холбоотойгоор ICP машиныг СЕХ-нд хүргэж, буцаан авч явахад 695.5 мянган төгрөг, буцаан СЕХ-нд хүргэхэд 1944.0 мянгөн төгрөг олгосон байна.

Унааны зардлыг 739.5 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгон сонгуулийн зардлыг хяналтгүй, үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байх тул төлбөрийн акт тогтоов.

Бүлэг.2 Сонгууль зохион байгуулах зардал, хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.1. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна.

СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолын 3-р хавсралтаар сумдын сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, аймгийн сонгуулийн хороо нэгтгэсэн байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооны зардлын нэгтгэсэн тайлангаар 215869.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 215869.5 сая төгрөгийг зарцуулж, хэтрэлт хэмнэлт үүсээгүй байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан
/мянган.төгрөг/

№	зардлын нэр		Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт , хэтрэлт
1	Сургалтын зардал		2,088.5	2,088.5	-
2	Тогтоол, протокол, маягт хэвлүүлэх		250.0	250.0	-
3	Бичиг хэргийн зардал		9,725.0	9,725.0	-
4	Шуудан холбооны зардал		9,840.0	9,840.0	-
5	Унааны зардал		17,150.0	17,150.0	-
6	Саналын хуудас устгах		300.0	300.0	-
7	Сурталчилгааны зардал		8,000.0	8,000.0	-
8	Сурталчилгааны материал хүргэх зардал		250.0	250.0	-
9	Санал авах байр бэлтгэх		8,600.0	8,600.0	-
10	Саналын хуудас хүргэх		2,118.0	2,118.0	-
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал		6,762.0	6,762.0	-
12	мэдээ дамжуулах зардал	МТБ-ийн холбооны зардал	200.0	200.0	-
		МТБ-ийн унааны зардал	1,000.0	1,000.0	-
		Даамал туршилтын болон санал авах өдөр мэдээ дамжуулах унааны зардал	300.0	300.0	-
13	Томилолтын зардал	Сонгуулийн дүнг СЕХ-нд хүргэх	588.0	588.0	-
		Сонгуулийн дүнг сум, дүүргийн сонгуулийн хорооноос аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргэх	208.0	208.0	-
		Аймгийн сонгуулийн хорооны нягтлан СЕХ-нд сонгуулийн зардлын тайлан хүргэх	446.0	446.0	-
14	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал		3,612.0	3,612.0	-
15	Болзошгүй зардал		3,000.0	3,000.0	-
16	Нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтны урамшуулал, хоолны зардал		1,700.0	1,700.0	-
17	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал		119,232.8	119,232.8	-
18	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал		20,499.2	20,499.2	-
	Дүн		215,869.5	215,869.5	-

Батлагдсан төсвийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдлийг тулгахад унааны зардал 13400.0 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн тооцооны хуудас хөтлөхгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Аймгийн сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-т “Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд хяналт тавина” гэж заасан байтал аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хэсгийн хороодын зардлын зарцуулалтанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Баян-Өндөр, Жаргалант сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын мэдээ, тайлан, анхан шатны баримтыг тулган баталгаажуулж, зардлаас бэлтгэсэн 1721.7 мянган төгрөгийн уртасгагч, галын хор, ус буцалгагч зэргийг бүртгээгүй, 57.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын суутгал хийгээгүй олгожээ. Иймд аудитаар 57.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг нөхөн төлүүлж, 1721.7 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

ИЛРҮҮЛЭЛТ:

“Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл” нийцлийн аудитаар 739.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1721.7 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 1 санал хүргүүлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “Сонгуулийн зардлыг бодитой төлөвлөөгүйгээс үр ашиггүй, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулж, аймгийн сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна” гэсэн дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- СЕХ нь төсвийг бодитой төлөвлөөгүй байна.
- Аймаг, сумын сонгуулийн хороод СЕХ-ны аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг хуваарилсан байна.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан хэдий ч анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулаагүй, төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүйгээр зарцуулжээ
- Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна.
- Аймгийн сонгуулийн хороо хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн ҮАГ-аар дамжуулан СЕХ-нд хүргүүлэх санал:

1. СЕХ нь төсвийн зардлыг орон нутгийн онцлогийг харгалзан бодитой төлөвлөж, төсвийн зарцуулалт болон хөрөнгийн бүртгэл хөтлөлтийн хяналтыг сайжруулах арга зүйгээр хангаж ажиллах.

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б. ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

В.ЖАВЗМАА

АУДИТОР

Г.ОРГИЛМӨРӨН

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ:

Аймгийн сонгуулийн хороо:



**ОРХОН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

61000 Эрдэнэт, Амарын талбай
Нутгийн удирдлагын ордон
Утас: 70355438, 99018688

2017. 07. 28 № 55

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын газраас ирүүлсэн тайлангийн төсөлтэй
танилцлаа биелэлтийг хугацаанд нь хэрэгжүүлэн
ажиллана.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Э.ДАШЗЭВЭГ

Хавсралт № 01

“Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл” нийцлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

Акт, албан шаардлагын дугаар	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцагч	Зөрчил хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
04/41-ОАГ-НА-2017/04	Унааны зардлыг илүү тооцоолж олгон сонгуулийн зардлыг хяналтгүй, үрэлгэн зарцуулсан	Аймгийн сонгуулийн хороо	дарга, нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Д.Соёлчхүү Э.Дашзэвэг О.Энхбаяр	739.5	
05/87-ОАГ-НА-2017/04	Зардлаас бэлтгэсэн уртасгагч, галын хор, ус буцалгагч зэргийг бүртгээгүй	Аймгийн сонгуулийн хороо	дарга, нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Д.Соёлчхүү Э.Дашзэвэг О.Энхбаяр		1,721.7
	Дүн				739.5	1,721.7

Төлбөрийн акт, албан шаардлага:


**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2017 оны 07 сарын 28 өдөр Дугаар 04/1-ОАГ-НА-2017/04 Эрдэнэт хот

Г ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ Г

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөгөөр "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлд хийх аудит" нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалттай холбоотойгоор санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах тээврийн хөлсийг 739,500 төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно", 3.1.3-д "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон тээврийн хөлс 739,500 төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь татварын бус хүү, торгуулийн орлогын 100210000914 дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон аймгийн сонгуулийн хорооны дарга Д.Соёлчхүү, нарийн бичгийн дарга Э.Дашзэвэг, нягтлан бодогч О.Энхбаяр нарт хариуцуулав.

07.01.22

АКТЫГ

ТОГТООСОН¹

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.НАРМАНДАХ
АХЛАХ АУДИТОР В.ЖАВЗМАА
АУДИТОР Г.ОРГИЛМӨРӨН

ЗӨВШӨӨРСӨН

ОРХОН АЙМГИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНЫ ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.ДАШЗЭВЭГ
НЯГТЛАН БОДОГЧ О.ЭНХБАЯР

¹ Акт, албан швэрдлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан швэрдлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж завсны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд сэнэл хүргүүлнэ.

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДАЛАГА

2017 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 05/87 -О.АГ-НА-2017/04

Эрдэнэт хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөгөөр "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлд хийх аудит" нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санал авах байруудын бэлтгэсэн 1,721,750 төгрөгийн үнэ бүхий галын хор, уртасгагч залгуур, ус буцалгагч зэрэг дахин ашиглагдах эд зүйлсийг нэгтгэн хүлээн авч бүртгэлд тусгаагүй, эзэнгүйдүүлж орхигдуулсан байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 4.1-д "сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", 4.1.2-д "өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

07.02.59

- Санал авах байруудын бэлтгэсэн 1,721,750 төгрөгийн үнэ бүхий галын хор, уртасгагч залгуур, ус буцалгагч зэрэг дахин ашиглагдах эд зүйлсийг нэгтгэн хүлээн авч бүртгэлд тусгаагүй, эзэнгүйдүүлж орхигдуулсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон аймгийн Сонгуулийн хорооны дарга /Д.Соёлчхүү/, нягтлан бодогч /О.Энхбаяр/, Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны гишүүн /Б.Ган-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.НАРМАНДАХ
АХЛАХ АУДИТОР В.ЖАВЗМАА
АУДИТОР Г.ОРГИЛМӨРӨН

ЗӨВШӨӨРСӨН

ОРХОН АЙМГИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНЫ ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ
БАЯН-ӨНДӨР СУМЫН СОНГУУЛИЙН
ХОРООНЫ ГИШҮҮН Б.ГАН-ЭРДЭНЭ
НЯГТЛАН БОДОГЧ О.ЭНХБАЯР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.